МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 14 өдөр Дугаар 141 Улаанбаатар хот

Хяналтын тоо, сургалтын
зардал батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 29 дүгээр зүйлийн 29.8, 31 дүгээр зүйлийн 31.2 дах заалт, Монгол Улсын Эрүүл мэнд, Спортын сайд, Сангийн сайдын хамтарсан "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 2015 оны 03 сарын 16-ны 97/56, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 491/А/472 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын хяналтын тоо болон төрийн зардлаар тэтгэлэгтэй суралцах суралцагчдын тоог нэгдүгээр, төрөлжсөн мэргэшлийн сургалтанд төрийн зардлаар тэтгэлэгтэй суралцах суралцагчдын тоог хоёрдугаар, 2015 онд төрийн зардлаар суралцуулах төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтын зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д, энэхүү тушаалаар батлагдсан төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын хяналтын тоог мөрдөж ажиллахыг төгсөлтийн дараах сургалт явуулах байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Г.Ганчимэг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т даалгасугай.

САЙД Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080481

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 14 өдрийн
191 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

## ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХЯНАЛТЫН ТОО БОЛОН ТӨРИЙН ЗАРДЛААР ТЭТГЭЛЭГТЭЙ СУРАЛЦАХ СУРАЛЦАГЧДЫН ТОО

| № | Сургалтын чиглэл | Хяналтын тоо | Тэтгэлэг авах суралцагчдын тоо |
|---|---|---|---|
| 1. | Дотор судлал | 58 | 24 |
| 2. | Өрхийн анагаах ухаан судлал | 15 | 10 |
| 3. | Хүүхэд судлал | 24 | 24 |
| 4. | Мэдээгүйжүүлэг судлал | 15 | 12 |
| 5. | Сэхээн амьдруулах/эрчимт эмчилгээ судлал | 15 | 10 |
| 6. | Яаралтай тусламж/ гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ судлал | 12 | 12 |
| 7. | Эх барих , эмэгтэйчүүд судлал | 30 | 28 |
| 8. | Мэс засал судлал | 20 | 12 |
| 9. | Гэмтэл- согог засал судлал | 20 | 6 |
| 10. | Чих, хамар, хоолой судлал | 8 | 3 |
| 11. | Нүд судлал | 6 | 4 |
| 12. | Мэдрэл судлал | 12 | 8 |
| 13. | Сэтгэцийн өвчин судлал | 12 | 6 |
| 14. | Арьс судлал | 15 | 5 |
| 15. | Халдварт өвчин судлал | 14 | 6 |
| 16. | Хавдар судлал | 10 | 5 |
| 17. | Сэргээн засал эмчилгээ судлал | 8 | 4 |
| 18. | Анатомын эмгэг судлал | 9 | 6 |
| 19. | Эмнэлзүйн эмгэг судлал | 10 | 4 |
| 20. | Дүрс оношлогоо судлал | 20 | 9 |
| 21. | Зүү төөнө засал судлал | 11 | 2 |
| Нийт | | 360 | 200 |

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 14 өдрийн
141 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

# ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТАНД ТӨРИЙН ЗАРДЛААР ТЭТГЭЛЭГТЭЙ СУРАЛЦАХ СУРАЛЦАГЧДЫН ТОО

| № | Сургалтын чиглэл | Суралцагчдын хяналтын тоо |
|---|---|---|
| 1. | Зүрх судасны өвчин судлал | 4 |
| 2. | Амьсгалын замын өвчин судлал | 2 |
| 3. | Шээс ялгаруулах замын өвчин судлал | 2 |
| 4. | Хоол боловсруулах эрхтний өвчин судлал | 3 |
| 5. | Цусны өвчин судлал | 2 |
| 6. | Дотоод шүүрлийн булчирхайн өвчин судлал | 3 |
| 7. | Эмнэлзүйн хор судлал | 2 |
| 8. | Хөнгөвчлөх эмчилгээ судлал | 1 |
| 9. | Настан судлал | 2 |
| 10. | Нярай судлал | 10 |
| 11. | Хүүхдийн зүрх судасны өвчин судлал | 3 |
| 12. | Хүүхдийн амьсгалын замын өвчин судлал | 4 |
| 13. | Хүүхдийн шээс ялгаруулах өвчин судлал | 2 |
| 14. | Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн булчирхай судлал | 2 |
| 15. | Пренаталь өвчин судлал | 2 |
| 16. | Эмэгтэйчүүдийн хавдар судлал | 5 |
| 17. | Хэвлийн хөндийн мэс засал судлал | 2 |
| 18. | Зүрх судасны мэс засал судлал | 1 |
| 19. | Шээс ялгаруулах замын мэс засал судлал | 2 |
| 20. | Хүүхдийн мэс засал судлал | 2 |
| 21. | Толгой хүзүүний мэс засал судлал | 2 |
| 22. | Хүүхдийн мэдээгүйжүүлэг судлал | 4 |
| 23. | Хүүхдийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ судлал | 4 |
| 24. | Зоонозын халдварт өвчин судлал | 2 |
| 25. | БЗДХ/ХДХВ/ДОХ судлал | 4 |
| 26. | Сүрьеэ судлал | 5 |
| 27. | Хүүхдийн мэдрэлийн өвчин судлал | 4 |
| 28. | Гавал тархи, нуруу нугасны гэмтэл судлал | 1 |
| 29. | Мөчдийн гэмтэл | 1 |
| 30. | Эсийн эмгэг судлал | 1 |
| 31. | Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 3 |
| 32. | Эмнэлзүйн эм судлал | 2 |
| 33. | Эмнэлзүйн бичил амь судлал | 2 |
| 34. | Цөмийн оношилгоо судлал | 1 |
| 35. | Дурангийн онош зүй | 7 |
| 36. | Соронзон давтамжит томографи судлал | 5 |
| 37. | Биостатистик, тархвар зүй | 4 |
| Нийт | | 108 |

# СУВИЛАХУЙ СУДЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТ

| № | Сургалтын чиглэл | Суралцагчдын тоо |
|---|---|---|
| 1. | Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй | 19 |
| 2. | Нярайн сувилахуй | 29 |
| 3. | Хүүхдийн сувилахуй | 31 |
| 4. | Эх барихын сувилахуй судлал | 8 |
| 5. | Мэдээгүйжүүлэг сувилахуй | 20 |
| 6 | Мэс заслын сувилахуй | 28 |
| 7. | Настны сувилахуй | 5 |
| 8. | Яаралтай тусламжийн сувилахуй | 24 |
| 9. | Дурангийн сувилагч | 10 |
| 10. | Гэмтэл согог заслын сувилахуй | 13 |
| 11. | Эрчимт эмчилгээний сувилахуй | 8 |
| 12. | Клиник биохимийн лаборант | 13 |
| 13. | Халдвартын сувилахуй | 10 |
| 14. | Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй | 9 |
| 15. | Мэдрэлийн сувилахуй | 9 |
| 16. | Сэтгэцийн эмгэгийн сувилахуй | 7 |
| 17. | Сэргээн засах эмчилгээний сувилахуй | 18 |
| 18 | Дархлаажуулалтын сувилахуй | 25 |
| 19 | Эмнэлгийн ариутгал судлал | 22 |
| 20 | Бүртгэл мэдээллийн ажилтан | 16 |
| 21 | Бариа заслын сувилахуй | 11 |
| 22 | Имунологийн лаборант | 6 |
| 23 | Хавдрын сувилахуй | 11 |
| 24 | Соронзон давтамжит томографийн техникч | 1 |
| 25 | Компьютер томографийн техникч | 1 |
| 26 | Ангио-оношилгоо эмчилгээний техникч | 1 |
| | Нийт | 355 |

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 14 өдрийн
141 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

## 2015 ОНД ТӨРИЙН ЗАРДЛААР СУРАЛЦУУЛАХ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Сургалтын төрөл | Суралцагчдын тоо | Төсөвлөсөн зардал |
|---|---|---|---|
| *Үндсэн мэргэшлийн сургалт:* | | | |
| 1. | 2012-2013 оны үндсэн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл | 126 | 47 232 000 |
| 2. | 2012-2013 оны үндсэн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл | 126 | 221 400 000 |
| 3. | 2014 оны үндсэн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл | 161 | 113 344 000 |
| 4. | 2014 оны үндсэн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл | 161 | 531 300 000 |
| 5. | 2015 оны үндсэн мэргэшлийн сургалтын зардал | 200 | 38 400 000 |
| *Төрөлжсөн мэргэшлийн сургалт:* | | | |
| 6. | 2014 оны төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл | 58 | 14 464000 |
| 7. | 2014 оны төрөлжсөн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл | 58 | 67 800 000 |
| 8. | 2015 оны төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардал /эмч/ | 108 | 20 736 000 |
| 9. | 2015 оны төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардал /сувилахуй/ | 355 | 68 928 000 |
| 10. | 2015 оны төрөлжсөн мэргэшлийн сургалтын тэтгэлэг /сувилахуй/ | 12 | 3 600 000 |
| *Мэргэжил дээшлүүлэх сургалт:* | | | |
| 11. | 2014 оны мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлын үргэлжлэл | 19 | 2 432 000 |
| 12. | 2014 оны мэргэжил дээшлүүлэх сургалтын тэтгэлгийн үргэлжлэл | 19 | 11 400 000 |
| 13. | 2015 оны мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал | 154 | 29 568 000 |
| *Мэргэжил дээшлүүлэх сувилахуй судлал:* | | | |
| 14. | 2015 оны мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал | 20 | 1 760 000 |
| *Багц цагийн сургалт:* | | | |
| 15. | Ажлын байрны сургалт | 2215 | 94 120 000 |
| 16. | Зайн сургалт | 3000 | 6 000 000 |
| *Бусад сургалт:* | | | |
| 17. | ЭМСЯ-ны бодлогын хүрээнд хийгдэх ''Удирдах ажилтны сургалт'' | 200 | 120 000 000 |

| | | | |
|---|---|---|---|
| 18. | Санхүү, эдийн засагчдын сургалт | 180 | 75 800 000 |
| 19. | Эрүүл мэндийн ажилтны гадаад сургалт | 92 | 890 362 000 |
| 20. | Тоног төхөөрөмжийн сургалт | 16 | 960 000 |
| 21. | ЭМСЯ-ны бодлогын хүрээнд хийгдэх "Өрх, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалт" | 1200 | 120 394 000 |
| 22. | Хүний нөөцийн менежерүүдийн сургалт | 50 | 18 000 000 |
| | **Нийт зардал** | | **2 498 000 000** |